



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 119

Арвайхээр

Малын халдварт, шимэгчтэх өвчнөөс  
урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүргийг халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний ажлыг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ныг хүртэлх хугацаанд эрчимжүүлэн зохион байгуулж ажилласугай.

2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих, товлосон хугацаанд мал сүргийг бэлэн байлгах ажлын хэсэг томилж, үүрэгжүүлж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газар, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулагдах тарилга болон зардлын хуваарийг баталгаажуулах, цаг хугацаанд нь татан авч хувийн мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүдэд хүргэх, мэргэжил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (А.Нямдаваа)-д даалгасугай.

4. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц, чанар үр дүнтэй уялдуулан санхүүжилт олгох болон холбогдох баримт бичгийн бүрдүүлэлт, мэдээ тайланд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга (А.Нямдаваа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100242